

Golomt Capital®

БОНДЫН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ



2025.08.06



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД

Нэр	Дуусах хугацаа	Купон	Өгөөж
Номад	2026.04.07	5.125%	5.94%
Монгол 27	2027.07.07	3.50%	6.22%
Хүннү	2028.01.19	8.65%	6.11%
Монгол 29	2029.06.05	7.875%	6.28%
Монгол 30	2030.02.25	6.625%	6.65%
Монгол 31	2031.07.07	4.45%	6.87%

Эх сурвалж: Bloomberg

Монгол Улсын Засгийн газар бондуудын өгөөж 5.95%-6.84% хооронд хэлбэлзэж байна.



КОМПАНИЙН БОНД (АМ.ДОЛЛАР)

Нэр	Дуусах хугацаа	Купон	Өгөөж
Голомт Банк (GLMT)	2027.05.20	11.00%	8.76%
МИК (MIK)	2027.01.18	11.50%	12.90%
TDBM	2027.12.23	8.5%	9.55%
DBM	2026.03.07	11.00%	6.70%

Эх сурвалж: Bloomberg

Компанийн ам.долларын бондуудын өгөөж 6.70%-12.90%-ийн түвшинд хэлбэлзэж, эрсдэлийг давж өндөр өгөөж хайж буй хөрөнгө оруулагчдын сонирхлыг татаж байна. Голомт Банк олон улсын зах зээлд жилийн 11%-ийн хүүтэй, 2027.05.20-нд хаагдах 300 сая ам.долларын бондыг амжилттай гаргасан бөгөөд хоёрдогч зах зээлийн арилжаагаар худалдан авах боломжтой хэвээр байна.

Golomt Capital

2021-2024 он

19%

дундаж хүү

Нийт

3.000

хөрөнгө оруулагч

Нэг хөрөнгө оруулагч

95сая₮

хүртсэн өгөөж

Одоо
₮20%БОНД АВАХ
₮10сая

ЖИШЭЭ

ХҮРТЭХ
₮2сая
ӨГӨӨЖ

\$ АМ.ДОЛЛАРЫН БОНДЫН СУУРЬ МЭДЭЭЛЛҮҮД

Ам.доллар үргэлжлэн суларсаар байна

Долларын эсрэг байр суурь яагаад давамгайлж эхлэв?

Холбооны Нөөцийн бодлого зөөлрөх төлөвтэй – 2025 оны 3-р улирлаас эхлэн АНУ-ын төв банк бодлогын хүүгээ бууруулж магадгүй гэсэн хүлээлт нэмэгдэж байгаа нь долларын ханшид сөргөөр нөлөөлнө гэсэн хүлээлтийг бий болгож байна.

АНУ-ын төсвийн алдагдлын өсөлт – “One Big Beautiful Bill” гэх шинэ төсвийн бодлого нь АНУ-ын өрийг огцом нэмэгдүүлж, ам.долларын нэр хүндийг бууруулах эрсдэл үүсгэж байна. Олон улсын төв банкууд алт болон бусад валют руу хөрөнгөө шилжүүлж буй – Энэ нь долларын нөөц валютын байр сууринд ан цав үүсч болзошгүйг илтгэж байна. Түүхэндээ анх удаа “Short US dollar” буюу долларын уналтад тоглолт хийж буй хөрөнгө оруулалт хамгийн түгээмэл, хамгийн эрсдэл өндөр төвлөрөлтэй арилжаа болжээ.

График 2. АНУ-ын 10 жилийн хугацаатай ЗГ-ын бондын өгөөж



Өнгөрсөн долоо хоногт ХНС-н ээлжит бодлогын хүүгийн хурал болж хүүг 4.25-4.5 хувийн түвшинд хэвээр нь хадгалах шийдвэр гаргасан. Үүнээс шалтгаалж АНУ-ын 10 жилийн хугацаатай ЗГ-ын бондын өгөөж 4.4%-иас 4.21% хүртэл унаад байна.

Мөн үүний дараа Nonfarm Payrolls мэдээ гарч АНУ-ын 7-р сарын ажил олголтын тоон мэдээ хүлээлтээс маш бага буюу 73,000 гарсан. Үүнээс шалтгаалж ам.долларын индекс хүчтэй сулрах болсон. Учир нь ажил олголтын тоо буурч байгаа нь эдийн засаг муудаж байгаагийн шинж бөгөөд энэ үед Төв банкнаас аль болох зөөлөн мөнгөний бодлогын баримтлах ёстой.

Тэгвэл ирэх 9-р сард бодлогын хүүгээ бууруулж эхлэх үү? Мэдээж бууруулах магадлал маш өндөр байгаа ба 8-р сарын 12-нд гарах инфляцийн тоо хүлээлтээс бага гарвал хүү буурч, долларын бондуудын өгөөж буурах шалтгаан болно.

ДОТООДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Биржийн бус зах зээлийн арилжааны мэдээ


2025 оны 7-р сарын 28-наас 8-р сарын 1-ний өдрүүдэд Бондын биржийн зохион байгуулалттай зах зээлд нийт 79,198 ширхэг үнэт цаас арилжигдаж, нийт 44.76 тэрбум төгрөг, 74.5 мянган ам.долларын үнийн дүн бүрдүүлжээ. Үүнээс анхдагч зах зээлд 22,157 ширхэг үнэт цаас 25.65 тэрбум төгрөгөөр, харин хоёрдогч зах зээлд 57,041 ширхэг үнэт цаас 19.11 тэрбум төгрөг, 74 ширхэг үнэт цаас 74,503.94 ам.доллараар тус тус арилжаалагдсан байна.

Биржийн бус зах зээлийн бондын өгөөжийн муруй

Бондын өгөөжийн муруй нь зах зээлд гарч буй бондуудын хугацаа болон өгөөжийн хамаарлыг нь илтгэдэг. Өгөөжийн муруйг дараах зорилгоор ашиглах боломжтой. Үүнд:

- Үнэт цаасны өгөөжийн хувь үнэт цаасны хугацаанаас хамааран хэрхэн ялгаатай тогтож байгааг мэдэх
- Шинээр гаргах үнэт цаасны үнэ ханш, өгөөжийг тогтоох жишиг хувь болох
- Бусад бондын өгөөжтэй харьцуулан шийдвэр гаргах боломжийг олгодог юм.

График 2. Бондын өгөөжийн муруй (2024.10-р сард бодлогын хүү өөрчлөгдсөнөөс хойш)



**ЗГҮЦ-НЫ АРИЛЖАА
3 ЖИЛИЙН ХУГАЦААТАЙ
БОНД ЗАХИАЛГА
АВЧ БАЙНА**

8083-7744 | 8665-4422 | 8665-1177